

# ПАРЛАМЕНТ ГЭЖ ЮУ ВЭ?



## Зорилт:

- Сурагчдын төлөөллийн байгууллага болох Сурагчдын зөвлөл, түүний үйл ажиллагааг судлах замаар иргэдийн төлөөллийн байгууллага болох парламентын талаар тайлбарлах



## Сэдвийн агуулга:

- Төлөөлөл
- Сурагчдын зөвлөл - сурагчдын төлөөлөл
- Парламентын тухай ойлголт

## Хичээлийн хэрэглэгдэхүүн:

- “Дэлхийн парламентууд” танилцуулга

## Сургалтын арга:

- Ярилцлага хийх

## Түлхүүр үг:

### Сурагчдын зөвлөл

Сургуулийн сурагчдын эрх ашгийг хамгаалах, тэдний өмнө тулгамдсан асуудлуудаар шийдвэр гаргах сурагчдын төлөөллийн байгууллага юм. Сурагчдын зөвлөлийн гишүүдийг сургуулийн сурагчид дундаасаа сонгоно.

### Сонгууль

Төлөөллийн байгууллагын гишүүн, сонгуульд албан тушаалтныг санал хураалтаар сонгох үйл явц. Сонгууль бол төрийн эрх мэдэл ард түмний мэдэлд байх ардчиллын үнэт зүйл юм.

### Төлөөлөгч

Бусдыг төлөөлж, шийдвэр гаргахад иргэдийн нийтлэг хүсэл сонирхлыг илэрхийлж оролцохоор сонгогдсон хүн.

### Парламент

Парламент бол ард түмнийг төлөөлөн хууль тогтоох онцгой бүрэн эрх бүхий төлөөллийн байгууллага юм. Дэлхийн улс орнууд парламентаа өөр өөрсдийн хуулийн дагуу байгуулна.

### Хууль батлах (тогтоох)

Хуулийн төслийг парламентаар хэлэлцэж, батлах үйл ажиллагаа. Хууль тогтоох үйл ажиллагааны үе шат, дарааллыг парламентын дэгээр тогтоодог. Хуулийн төслийг парламент хэлэлцэхийн өмнө олон нийтээр хэлэлцүүлэх, тэдний саналыг авах зэргээр иргэдийн оролцоог хангадаг.

### Сонгуулийн тойрог

Сонгуулийг зохион байгуулахаар тухайн улсын нутаг дэвсгэрийг хүн амын тоо, газар зүйн байршлын хувьд хуваасан хэсгийг хэлнэ.

## Үйл ажиллагаа

### 1. Сэдэлжүүлэлт

"Бусдыг төлөөлөх гэж юу вэ?", "Өмнө нь хэн нэгэн хүн, эсхүл бусдыг төлөөлж байсан уу?" гэж асууна.

### 2. Шинэ мэдлэг бүтээх

а) **Мэдээлэл унших, асуултад хариулах:** Сурагчийн гарын авлагыг сурагчдаар бие даан уншуулна. Гарын авлагыг уншиж дууссаны дараа сурагчдын дунд дараах асуултын хүрээнд ярилцлага хийнэ. Үүнд:

- Анги бүрээс сонгогдсон Сурагчдын зөвлөлийн гишүүд ямар үүрэгтэй вэ?
- Тэд хэрхэн ажилладаг вэ?

б) **Ярилцлага хийх:** "Дэлхийн парламентууд" танилцуулгыг (презентейшн) сурагчдад үзүүлнэ. Сурагчдын ярилцлагыг дараах асуултын хүрээнд чиглүүлээрэй. Үүнд:

- Парламент гэж юу вэ? Та бүхэнд парламентын талаар ямар мэдээлэл байна вэ?
- Яагаад улс орон бүрд парламент байдаг юм бол?

### 3. Бататгал

- Дасгал ажлын хуудсыг хувилаад сурагчдад тарааж өгнө.
- Дасгалыг хэрхэн хийх зааврыг танилцуулж, гүйцэтгэх хугацаа олгоно.

#### Дасгал ажил 1.

"Сурагчдын зөвлөл" дасгал ажлын хуудсанд хэрхэн Сурагчдын зөвлөлийн гишүүн болдог, Сурагчдын зөвлөлийн гишүүний эрх, үүргийг бичнэ үү.


#### Дасгал ажил 2.

Хүснэгтийн 2 баганад байрлах улсын нэр болон парламентын нэрийг зөв харгалзуулан холбоно. Дасгалыг хийж дууссаны дараа өөр ямар улс парламентаа юу гэж нэрлэдгийг интернэтээс хайж мэднэ.

### Хяналтын асуулт:

1. Сурагчдын зөвлөл хэнийг төлөөлж, юу хийдэг вэ?
2. Парламент гэж юу вэ?
3. Парламент хэнийг төлөөлдөг вэ?
4. Парламентын үндсэн үүргийг нэрлэнэ үү.

Дасгал 1.



ПАРЛАМЕНТЫН  
БОЛОВСРОЛ

ОВОГ, НЭР: \_\_\_\_\_

АНГИ: \_\_\_\_\_

ОГНОО: \_\_\_\_\_

Хүүхдүүд ээ, бусдыгаа төлөөлнө гэдэг маш хариуцлагатай ажил шүү.

- Сурагчдын зөвлөл гэж юу вэ? Сурагчдын зөвлөл хэрхэн бүрддэг вэ?

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

- Сурагчдын зөвлөлийн гишүүн ямар эрхтэй вэ?

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

- Сурагчдын зөвлөлийн гишүүн ямар үүрэг хүлээх вэ?

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

- Сурагчдын зөвлөлийн гишүүн ямар хариуцлага хүлээх ёстой талаар өөрийн бодлоо хуваалцана уу.

\_\_\_\_\_

\_\_\_\_\_

\_\_\_\_\_



12-14 нас

## Парламент гэж юу вэ?

Дасгал 2.

1	Альтинг	АНУ	А
2	Бундестаг	Финланд	Б
3	Едус Кунта	ХБНГУ	В
4	Конгресс	Монгол	Г
5	Үндэсний Ассамблей	БНСУ	Д
6	Улсын Их Хурал	Исланд	Е
7	Коккай	Япон	Ё

Хариу: 1Е, 2В, 3Б, 4А, 5Д, 6Г, 7Ё